



ТЕРРОРИЗМ ГЭЖ ЮУ ВЭ?

ТЕРРОРИЗМ гэдэг нь улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдаст автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа юм.

Терроризм нь энгийн иргэд, төрийн байгууллага, эдийн засаг болон нийгмийн тогтвортой байдалд заналхийлдэг.

Терроризмын үндсэн шинж чанар:

1. Айдас төрүүлэх зорилготой – Иргэд болон байгууллагад айдас түгшүүр бий болгох замаар нийгмийг хяналтдаа байлгахыг оролддог.
2. Улс төр, шашин, үзэл сурталтай холбоотой зорилго – Энгийн гэмт хэрэгтэй харьцуулахад тодорхой идеологи буюу үзэл суртал дээр суурилсан байдаг.
3. Хүчирхийлэл ба заналхийлэл – Дэлбэрэлт, зэвсэгт халдлага, барьцаалах зэрэг хүчирхийллийн үйлдэл хийдэг.
4. Иргэд, төрийн төлөөлөгчдийг онилох – Тодорхой бүлэг хүмүүсийг айлгах замаар бусдыг нөлөөлөх зорилготой.

Терроризмтой тэмцэх үйл ажиллагааг дараах хууль тогтоомжоор зохицуулдаг:

1. ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ
2. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ
3. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
4. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
5. “ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ” (ЗАСГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ 464 ДҮГЭЭР ТОГТООЛ)
6. “МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ” (МОНГОЛ БАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2019 ОНЫ А-26 ДУГААР ТУШААЛ)



Терроризмоос урьдчилан сэргийлэх талаар хүн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг

ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИАС:

14 дүгээр зүйл.Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос урьдчилан сэргийлэх талаар хүн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг

14.1.Хүн, хуулийн этгээд зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

14.1.1.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой холбоотой мэдээ, мэдээллийг төрийн байгууллагад даруй өгөх;

14.1.2.террорист үйлдэл, үйл ажиллагаанд өдөөн хатгасан аливаа явуулга, суртал ухуулга, үзэл санаанд автахгүй байх;

14.1.3.терроризмыг сурталчлах, олон нийтэд уриалах, нийтийн өмнө зөвтгөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх;

14.1.4.терроризмоос сэргийлэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг явуулах, хохирол, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх

14.2.Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүү, бусад бүх төрлийн үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хориглоно.



УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТУУДЫГ ТЕРРОРИЗМООС ХАМГААЛАХ ТАЛААР

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дор дурдсан байгууллагын хүч хэрэгсэл, оролцооны тусламжтайгаар улсын онц чухал объектуудыг хамгаалдаг. Үүнд:

- Тагнуулын төв байгууллага, түүний төв болон орон нутаг дахь салбар, нэгж;
- Цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан байгууллага;
- Улсын хил хамгаалах байгууллага;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;
- Онцгой байдлын байгууллага;
- Дотоодын цэргийн штаб, анги, салбар;
- Терроризмтой тэмцэх Зөвлөлийн бусад бүрэлдэхүүн байгууллага;
- Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн захирамжаар томилогдсон зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар
- Төрийн тусгай хамгаалалтын байгууллага

Тагнуулын төв байгууллага, түүний төв болон орон нутаг дахь салбар, нэгж байгууллагын мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн томилгоот хэсэг нь террорист үйлдлийн үед тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологийн бодис болон хүчтэй үйлчлэх хорт бодис илрүүлэх, аюулгүй болгох ажиллагааг гүйцэтгэнэ.



УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТУУДЫГ ТЕРРОРИЗМООС ХАМГААЛАХ ТАЛААР

Улсын онц чухал объектуудыг “Дотоодын цэргийн анги” хэмээх тусгай нэгж хамгаалдаг. Тус анги нь Төрийн тусгай хамгаалалтын газар (ТТХГ)-ын харьяа бөгөөд улс орны стратегийн ач холбогдолтой, онцгой хамгаалалт шаарддаг объектуудыг (төрийн ордон, төрийн өндөр албан тушаалтны ордон, стратегийн байгууламж гэх мэт) хамгаалах үүрэгтэй.

Дотоодын цэргийн ангийн гол үүрэг:

1. Төрийн тусгай хамгаалалт шаарддаг байгууламжийг манаа, хамгаалалтад авах.
2. Улсын чухал стратегийн объект (эрчим хүч, ус, холбоо, дэд бүтэц гэх мэт) болон төрийн байгууллагын аюулгүй байдлыг хангах.
3. Онцгой нөхцөл байдал, терроризмын халдлагын үед шуурхай арга хэмжээ авах.
4. Төрийн тусгай хамгаалалттай холбогдох хууль, дүрмийн хэрэгжилтийг хангах, онцгой байдал, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах.

Ус сувгийн удирдах газрын унд усны эх үүсвэрүүд нь стратегийн чухал дэд бүтцийн ангилалд хамаарах тул дотоодын цэргийн ангийн хамгаалалтад байдаг. Ялангуяа нийслэл Улаанбаатар хотын усны хангамж, бохир ус зайлуулах систем нь нийгэм, эрүүл ахуй, аюулгүй байдалд шууд хамааралтай тул хамгаалалт шаардсан объект гэж тооцогддог.



ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн **ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ** хуульд заасны дагуу Терроризмтой тэмцэх зөвлөлөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг:

- Терроризмын нөхцөл байдал, түүний суурь нөхцөлийг үнэлэх;
- Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- Терроризмын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, терроризмоос ангид байх үзлийг төлөвшүүлэх;
- Терроризм үл нутагших, террорист этгээд нэвтрэхгүй, орогнохгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх;
- Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангах;
- Хүн, хуулийн этгээд, улсын онц чухал объект, хүн ам олноор төвлөрсөн газрыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;
- Террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, түүнээс үүсэх хохирол, хор уршгийг багасгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Зэвсэг, бодис, хэрэгсэл, юмсыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;
- Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах;
- Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхэд хүн, хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.